

“СОЛОМОН ИНВЕСТМЕНТС БЭСБ”
ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн
2026 оны 03 сарын 26 өдрийн 26/25 тоот
тогтоолын Хавсралт № 01



SOLOMON INVESTMENTS

ШҮГЭЛ ҮЛЭЭХ БОДЛОГО

Баримт бичгийн төрөл/ Type: **ШҮГЭЛ ҮЛЭЭХ БОДЛОГО**

Хамрах хүрээ/ Area:	“СОЛОМОН ИНВЕСТМЕНТС БЭСБ” ХХК-ийн ажилтнуудад
Нууцын зэрэглэл/ Confidentiality:	Дотоодод нээлттэй
Баримт бичгийн дугаар/Number:	...м./26./39....
Боловсруулсан/ Prepared by:	Төлөөлөн удирдах зөвлөл
Баталсан/ Approved by:	“СОЛОМОН ИНВЕСТМЕНТС БЭСБ” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл
Хуудасны тоо/ Page number:	4 хуудас
Хянан нийцүүлэх давтамж:	Жилд 1 удаа
Батлагдсан огноо/ Effective date:	2026 оны 03 сарын 26

АГУУЛГА

Гарчиг

НЭГ.НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ.....	4
ХОЁР.БОДЛОГЫН ЗОРИЛТ	4
ГУРАВ. ШҮГЭЛ ҮЛЭЭХ БОДЛОГО.....	4
ДӨРӨВ. ШҮГЭЛ ҮЛЭЭХ ПРОЦЕСС	5
ТАВ. ЗӨРЧИЛ ШАЛГАН ШИЙДВЭРЛЭХ	5
ЗУРГАА. ХАРИУЦЛАГА.....	5

НЭГ.НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Энэхүү Соломон Инвестментс ББСБ ХХК (цаашид "компани"гэх)-ийн Шүгэл үлээх бодлого (цаашид "Бодлого" гэх)-ийн зорилго нь шүгэл үлээх үйл ажиллагаа, түүнд баримтлах зарчим, шүгэл үлээх процесс, зөрчил шалган шийдвэрлэх, шүгэл үлээгчийн мэдээллийг хамгаалах, урамшуулал олгохтой холбоотой харилцааг зохицуулахад оршино.
- 1.2. Компани нь үйл ажиллагаандаа дотоодод хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Компанийн засаглалын кодексыг мөрдөж ажиллана.

ХОЁР.БОДЛОГЫН ЗОРИЛТ

- 2.1. Бодлогын зорилт:
 - 2.1.1. хувьцаа эзэмшигчийн эрхийг баталгаажуулах;
 - 2.1.2. Хууль, дүрэм, журмын зөрчил, хууль бус үйлдэл үйлдэгдэхээс урьдчилан сэргийлэх, аливаа хууль бус үйлдлийн үр нөлөөд Компанид болон хувьцаа эзэмшигчид хохирол учруулахаас хамгаалах;
 - 2.1.3. эрсдэлийн удирдлагыг сайжруулах;
 - 2.1.4. хяналтын тогтолцоог сайжруулах.

ГУРАВ. ШҮГЭЛ ҮЛЭЭХ БОДЛОГО

- 3.1. Компани нь дотооддоо шүгэл үлээх соёлыг бий болгох зорилгоор дараах зарчмыг баримтална. Үүнд:
 - 3.1.1. Компанийн тухай хууль, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль, Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хууль, Татварын багц хуулиуд болон холбогдох бусад хууль, Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан дүрэм журам болон эрх бүхий байгууллагаас баталсан холбогдох бусад дүрэм журмын хэрэгжилтийг хангах, дагаж мөрдөх биелүүлэх нь Компанийн ажилтан бүрийн үндсэн үүрэг байна.
 - 3.1.2. Холбогдох хууль, тогтоомж, дүрэм, журмыг зөрчсөн, ёс зүйгүй, шударга бус үйлдэл, байгууллагын болон ажилтнуудын ашиг сонирхлыг хүндэтгэж, аюулгүй байдлын эсрэг үйлдэлтэй тэмцэх нь ажилтан бүрийн үүрэг байна.
 - 3.1.3. Компанийн ажилтан бүр зөрчлийг нэн даруй мэдэгдсэнээр байгууллага болон ажилтныг хамгаалах, зөрчлийг төслөн зогсоох, учирч болзошгүй аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх эсхүл бууруулах ач холбогдолтой гэдгийг ухамсарлана.
 - 3.1.4. Компани нь шүгэл үлээсэн ажилтныг ямар ч тохиолдолд хамгаалж, шүгэл үлээгчийн талаарх мэдээллийг чандлан нууцална.
 - 3.1.5. Шүгэл үлээсэн ажилтны мэдээллээр байгууллагад учирч болзошгүй байсан эрсдэлийг бууруулсан, таслан зогсоосон, хууль эрх зүйн, санхүүгийн , нэр хүндийн болон аливаа эрсдэл гарахаас сэргийлсэн гэж үзсэн тохиолдолд

шүгэл үлээж зөрчил мэдээлсэн ажилтны хувь нэмрийг цаг алдалгүй үнэлж, урамшуулна.

- 3.1.6. Компани нь зүй бус үйлдлийг нэн даруй хариуцлагатайгаар таслан зогсоож арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

ДӨРӨВ. ШҮГЭЛ ҮЛЭЭХ ПРОЦЕСС

- 4.1. Компанийн аливаа ажилтан бүр Компанийн болон ажилтнуудын ашиг сонирхлыг хохироосон, хохироож болзошгүй бодит нөхцөл бүрдсэнийг олж мэдсэн, Компанийн дотоод дүрэм, журам, холбогдох хууль тогтоомж зөрчигдсөн, зөрчигдөж болзошгүй нөхцөл бүрдсэн, аль нэг ажилтан ёс зүйн зөрчил гаргасан, гаргахаар завдсан тохиолдлыг мэдсэн даруйдаа доорх сувгуудыг ашиглан Компанийн Ёс зүйн хороонд шүгэл үлээж мэдэгдэнэ. Үүнд:
- Цахим хаяг: support@mcredit.mn
 - Утас: 72002060
 - Биечлэн уулзах;
 - Бичгээр
- 4.2. Шүгэл үлээгч нь зөрчлийн талаар мэдээлэхдээ үнэн бодит үйлдэл, баримтын талаар мэдсэн, харсан зүйлээ мэдэгдэнэ.
- 4.3. Шүгэл үлээгч нь өөрийн мэдээлсэн зөрчлийг нотлох үүрэг хүлээхгүй боловч зөрчлийг цаг алдалгүй таслан зогсоох, үнэн зөв шийдвэр гаргаж цаашид авах арга хэмжээг цаг алдалгүй авахад туслах зорилгоор зөрчлийн талаарх нэмэлт мэдээлэл, нотлох баримтыг гаргаж өгч болно.
- 4.4. Шүгэл үлээгч нь энэхүү журмын 4.1 дэх хэсэгт заасны дагуу мэдээлэхдээ дараах зүйлийг дурдсан байна. Үүнд:
- Зөрчил гаргасан этгээдийн нэр, албан тушаал;
 - Шүгэл үлээх болсон нөхцөл байдал, үйлдлийн тайлбар;
 - Шүгэл үлээгчийн холбоо барих мэдээлэл

ТАВ. ЗӨРЧИЛ ШАЛГАН ШИЙДВЭРЛЭХ

- 5.1. Шүгэл үлээгчийн мэдээллийн дагуу зөрчлийг Ёс зүйн хороо, эрх бүхий алба тушаалтан холбогдох хууль тогтоомжийн дагуу шаган шийдвэрлэнэ.
- 5.2. Шүгэл үлээгчийн мэдээллийн дагуу шалгахад зөрчил нь гэмт хэргийн шинжийг агуулж байвал Компани нь уг үйлдлийг нэн даруй хуулийн байгууллагад мэдээллэж, шийдвэрлүүлнэ.

ЗУРГАА. ХАРИУЦЛАГА

- 6.1. Ажилтан нь хууль бус үйлдлийг мэдсээр байж мэдээлэхгүй өнгөрөөсөн нь түүнд сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно.

—ooOoo—